

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Бямба-Очир	Дугаар	L289
Оршин суугаа аймаг	Хөвсгөл аймаг	Оршин суугаа сум	Эрдэнэбулган сум
Төрсөн газар	Эрдэнэбулган сум	Төрсөн он	1929
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Дэлэнгийн дуган, Удганы хүрээ	Сүм хийдийн дугаар	ХӨЭБ 055, ХӨЭБ 054
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 19	Ярилцлага авсан хүн	Д .Мөнхбат

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Дэлэнгийн дуган, Удганы хүрээ

Мөнхбат: Тэгэхээр танаас дараах асуултуудыг тавъя.Үүнд нэгдүгээрт одоо энэ Дэлэнгийн дуган гэж байсан тэр цаг үед та одоо зургаа долоон настай хүүхэд байсан байна.Одоо таны ярианаас үзэхэд, ямар нэгэн байдлаар одоо мэдээ орчихсон ийм одоо настай тийм үе байжээ.Тэгэхээр тэнд ерөөсөө ганц л дуган байсан юм үү?

Бямба- Очир: Ганцхан л дуган байсан гэж манай ээж аав ярьдаг байсан юм аа. Тэр ганц дуганд бол ерөөсөө тэр дуганд зул өргөдөг, одоо тэр бурхан сахиусыг нь арилгаж цэвэрлэж одоо арчилж цэвэрлэж байдаг, сан хөмрөг тавьж байдаг нэг тийм лам байсан гэдэг юм. Аа тэгэхдээ тэр дуганд бол юу яадаг. Цаг цагт нэг хааяа тэр Удганы хүрээнээсээ лам нар ирж ном уншиж одоо хурал хурдаг байсан гэж манай аав ээж ярьдаг байсан юм аа.

Мөнхбат: Тэгэхээр одоо Удганы хүрээний салбар, түр цагийн байдлаар ажилладаг ийм дуган байжээ гэж одоо ойлгож болохоор байна, тийм ээ?

Бямба-Очир: Тийм ээ тийм. Тийм, тийм тэр ч одоо Удганы хүрээний салбар одоо хаашаа юм. Одоо тэр Архны дуган гэдэг шиг л одоо энэ чинь Удганы хүрээний салбар тийм л дуган байсан байгаа юм.

Мөнхбат :Тэгэхээр одоо ер нь ингээд баримжаалвал тэр Удганы хүрээний одоогийн байгаа тууриас тэр Дэлэнгийн дуганы туурь хүртэл хоорондоо энэ хоёр чинь хичнээн орчим км зайд байх бол?

Бямба-Очир: Гуч гаран км байгаа биз.Гуч гаран км, одоо Удганы хүрээнээс чинь хашаагаа, Бөөрөлзгөнөө өгсөөд л тэгээд л Бургалтайгаар дайраад Өлийн даваагаар даваад Өлийн давааны наад талд одоо тэр Дэлэн гэдэг дээр, Дэлэн булаг гэдэг дээр гэдгийн эхэн дээр байсан байгаа юм.

Мөнхбат :Тэгэхээр магадгүй гуч орчим км газар, тухайн үед ингээд зам тээвэр өнөөдрийнх шиг хөгжчихсөн байх юм биш.Хүн болгон мориор шогшуулж очоод л хурал номонд суугаад байна гэдэг хүн болгон бас хийчихээр ажил биш ,тийм ээ. Тэгэхээр магадгүй сүсэгтэн олондоо ойртож үйлчлэх зорилгын үүднээс тэр одоо газрыг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бараадуулж, сүсэгтэн олныхоо хөлийг бараадуулж тийм одоо салбараа Удганы хүрээ нээжээ гэж бас ингэж тийм таамаглал дэвшүүлж болох юм тийм ээ?

Бямба-Очир: Тийм тийм. Одоо тэр сүсэгтэн олондоо ойртуулж тийм хүрээ хийд барьж байсан байж болох юм. Аа одоо тэр дуганд Булган талыг ерөнхийд нь даатгаж тэтгэх сахиус бүрхны дамжлага байсан ч байж болох юм л даа. Тэр чинь юу ч байж болох юм.

Мөнхбат: Тэгэхээр одоо дуганы тэр байгаа туурь тэр Дэлэнгийн булаг гэдэг газар бол ямар ч байсан эндээс баримжаагаар одоо өөрөөр хэлбэл Эрдэнэбулган сумын төвөөс хэд орчим км зайтай байна? Ямар багийн нутагт орж байна?

Бямба-Очир: За тэр бол одоо энэ Эрдэнэбулган сумын хоёрдугаар багийн нутаг. Сумын төвөөсөө тав орчим км газар байгаа.

Мөнхбат: Тавь уу?

Бямба-Очир: Тав.

Мөнхбат: Өө тэгвэл их ойрхон, таван км ойрхон байгаа юм байна тийм ээ. Тэгэхээр одоо ингээд энэ туурин дээр очиход, ингээд таван км яваад энэ туурин дээр очиход буурь ором туурийн хувьд одоо ямар янзтай байгаа вэ?

Бямба-Очир: Байхгүй ээ, тэнд одоо туурь гэж хэлэх юм байхгүй. Одоо тариалангийн талбай болчихсон. Нийтдээ хавтгай хар шороо л бий.

Мөнхбат: Харин би энэ мэдээллийг бас сумын удирдах хүмүүсээс авсан юм. Тариан талбайд л орчихсон байж магадгүй гэсэн нэг ийм яриа байсан юм аа. Хуучин нөгөө Эгүүрийн сангийн аж ахуй гэж ажиллаж байх үед тийм ээ, тариаланд оруулчихсан...

Бямба-Очир: Одоо чиг одоо энэ дээр энэ компаниуд газрыг нь хагалаад яачихсан тариан талбай л даа.

Мөнхбат: Тэр энэ Дэлэнгийн дуганы ойролцоо одоо орон нутгийн тахилгатай, за мөн одоо тахихаа байсан байж болно. Эрт дээр үеэс тахилгатай ямар нэгэн уул овоо ус булаг шанд ийм газар орчин байдаг уу?

Бямба-Очир: Энд болвол одоо энэ Булган тал дээрээсээ ганц том овоо байдаг юм. Наранмандлын овоо гэж.

Мөнхбат: Эрдэнэбулган талаасаа?

Бямба-Очир: Тийм. Энэ Булган талдаа, энэ Булган тал гэдэг чинь одоо энэ харагдаж байгаа орчноо л тойроод энэ.

Мөнхбат: Наранмандлын овоо?

Бямба-Очир: Тийм. Наранмандлын овоо гэж нэг овоо байдаг юм аа.

Мөнхбат: Наранмандлын овоо энэ Дэлэнгийн дуганаасаа аль зүгт хэд орчим км-т байдаг юм бол?

Бямба-Очир: Наранмандлын овоо энэ Дэлэнгийн тууриас зүүн тийшээгээ мөн нэг дөрөв таван орчим км газарт байгаа.

Мөнхбат: Аа тэгвэл их ойрхон л байдаг юм байна, тийм ээ?

Бямба-Очир: Ойрхон.

Мөнхбат: Энэ Наранмандлын овоо одоо энэ тахилгатай юу?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Бямба-Очир: Одоо энийг хааяа энэ компаниуд тахидаг л юм гэсэн. Одоо тэгээд зунд нь энд хүн амьтан байдаггүй болохоор ерөөсөө энэ компаниуд л тахихаас тэгж энэ зарлаад олон нийтээрээ очиж тахих юм алга.

Мөнхбат: Тэгээд энэ сум маань үндсэндээ бол сүм хийд алга байна, лам нар байхгүй байна, үндсэндээ тийм ээ?

Бямба-Очир: Сүм хийд байхгүй, лам нар байхгүй. Наранмандлын овоог тахих нь ч байдаггүй. Даяндээрхийн ганц боссон дугандаа очоод суух ламгүй ш дээ, манай энэ чинь.

Мөнхбат: Тийм бололтой юм аа. За ингээд ямар ч байсан бид нар Эрдэнэбулган сумын төвөөс шинэ мэдээлэлтэй болсон.Энэ шинэ мэдээлэл маань ямар ч байсан өнөөдөр монголын буддын шашны сүм хийдийн түүхэн товчоонд одоо шинэ нэрээр орж ирж байна.Энэ бол Дэлэнгийн дуган гэж Эрдэнэбулган сумын төвөөс таван км зайтай орших.Магадгүй бид нарын таамагласнаар Удганы хүрээний салбар байж болох энэ одоо нэг дуганы түүрийн тухай товчхон мэдээллийг авлаа.Ингээд энэ талын мэдээллийг товч бөгөөд тодорхой өгсөн Бямба-Очир гуай таньд баярлалаа.